

ХУДАЛДАА ЭРХЭЛДЭГ АЖ АХУЙН НЭГЖИЙН ХҮНСНИЙ ГОЛ НЭР ТӨРЛИЙН БАРААНЫ ТАТАН АВАЛТ, ҮЛДЭГДЛИЙН 20... ОНЫ ...-Р УЛИРЛЫН МЭДЭЭ

А. Хаягийн хэсэг

Регистрийн дугаар						
нэр						
Аймаг, нийслэл						
Сум, дүүрэг						
Аж ахуйн нэгжийн нэр						
Үйл ажиллагааны салбарын чиглэл						

1. Аж ахуйн нэгжүүд 1, 4, 7, 10-р сарын 15-ны дотор сумын тамгын газар, дүүргийн статистикийн хэлтэст хүргүүлнэ.
2. Сумын тамгын газар, дүүргийн статистикийн хэлтэсээс 1, 4, 7, 10-р сарын 18-нд аймаг, нийслэлийн статистикийн газар, хэлтэст хүргүүлнэ.
3. Аймаг, нийслэлийн статистикийн газар, хэлтэс 1, 4, 7, 10-р сарын 21-нд цахим шуудангаар Үндэсний Статистикийн Хороонд дамжуулна.

Б. Үндсэн мэдээлэл

Биет хэмжээгээр

Барааны нэр	ХН	МД	Эхний үлдэгдэл	Татан авалт	Эцсийн үлдэгдэл	Бараагаа татаж авдаг байгууллага: Бөөний худалдааны төвөөс Үйлдвэрийн газраас шууд Импортлоор шууд
А	Б	В	1	2	3	4*
Мах, махан бүтээгдэхүүн						
Хонины мах	т	1				
Үхрийн мах	т	2				
Адууны мах	т	3				
Тэмээний мах	т	4				
Ямааны мах	т	5				
Гахайн мах	т	6				
Хиам	т	7				
Сүү, сүүн бүтээгдэхүүн						
Савласан сүү	мян.л	8				
Тараг	мян.л	9				
Аарц	кг	10				
Өндөг						
Өндөг /дотоод/	мян.ш	11				
Өндөг /гадаад/	мян.ш	12				
Ургамлын тос /1л/	мян.л	13				
Гурил, гурилан бүтээгдэхүүн						
Гурил /дотоод/	т	14				
Гурил /гадаад/	т	15				
Бүх төрлийн будаа	т	16				
Саахар, чихрийн зүйл						
Чихэр	т	17				
Элсэн чихэр	т	18				
Төмс						
Төмс /дотоод/	т	19				
Төмс /гадаад/	т	20				
Хүнсний ногоо						
Байцаа	т	21				
Манжин	т	22				
Лууван	т	23				
Сонгино	т	24				
Сармис	кг	25				
Өргөст хэмх	т	26				
Улаан лооль	т	27				

*4 дүгээр баганад бараагаа татан авдаг байгууллагын кодыг нөхнө. Олон байгууллагаас татан авдаг бол бараа татан авалтад дийлэнх хувь эзэлж байгаа байгууллагын кодыг нөхнө

Дарга /захирал, эзэн/ /

Ерөнхий /ахлах/ нягтлан бодогч /

Тамга

Маягт нөхөх заавар ХУ-16

Энэхүү мэдээг худалдаа эрхэлдэг, өмчийн бүх төрлийн аж ахуйн нэгж тогтоосон хугацаанд үнэн зөв гаргаж мэдээлнэ.

А. Хаягийн хэсэг

Оршин байгаа аймаг, нийслэл, сум, дүүргийн нэрийг бичин, кодыг аймаг, нийслэл, дүүргийн статистикийн хэлтсийн мэргэжилтнүүд Үндэсний Статистикийн газар /хуучин нэрээр /-ын даргын 2001 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 189 дүгээр тушаалаар батлагдсан кодыг ашиглан нөхнө. Аж ахуйн нэгжийн нэр, регистрийн дугаарыг тухайн аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээг үндэслэн, үйл ажиллагаа явуулж байгаа салбарын чиглэлийн кодыг Үндэсний статистикийн газар /хуучин нэрээр/-ын дарга, Сангийн сайдын хамтарсан 2006 оны 11-р сарын 17-ны өдрийн 01/129/376 тоот тушаалаар батлагдсан "Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал"-4.0 хувилбарын дагуу нөхнө.

Б. Үндсэн мэдээллийн хэсэг

Б хэсэгт тухайн аж ахуйн нэгжийн хүнсний гол нэр төрлийн барааны тайлант улирлын татан авалт, эхний болон эцсийн үлдэгдлийн талаарх мэдээллийг нөхнө.

1 дүгээр баганад тухайн барааны тайлант улирлын эхний үлдэгдлийг биет хэмжээгээр тодорхойлно.

2 дугаар баганад тайлант улирлын туршид татан авсан барааны биет хэмжээг бичнэ. .

3 дугаар баганад тайлант улирлын эцэст байгаа барааны биет хэмжээг бичнэ. Энэ нь тайлант улирлын барааны эхний үлдэгдэл дээр татан авсан барааны биет хэмжээг нэмж, борлуулсан барааны биет хэмжээ болон тайлант улирлын хорогдлыг /хэрэв хорогдол байгаа бол/ хассан дүнтэй тэнцэнэ.

4 дүгээр баганад бараа тус бүрийн татан авдаг байгууллагын арын кодыг нөхнө. Жишээ нь: хиамыг бөөний худалдааны төвөөс авдаг бол 7 дугаар мөрний 4 дүгээр баганад 1 гэсэн кодыг нөхнө. Хэрэв хиамыг бөөний худалдааны төв, шууд үйлдвэрээс хоёулангаас авдаг боловч бөөний худалдааны төвөөс дийлэнх хувийг авдаг бол 1 гэсэн кодыг нөхнө.

Барааны тодорхойлолт

1 дүгээр мөр. Хонины мах: Цул, ястай бүх төрлийн махыг оруулна. Гэдэс, дотор, толгой, шийр болон хагас боловсруулсан хонины махыг оруулахгүй. Хагас боловсруулсан хонины маханд тусгайлан бэлтгэсэн мөн жигнэсэн, лаазалсан, татсан махыг оруулна. Жишээ нь: Ханбүргэдэй ХХК-ий хоолонд бэлтгэсэн хонины мах гэх мэт.

2 дугаар мөр. Үхрийн мах: Гол, цул, ястай бүх төрлийн махыг оруулна. Гэдэс, дотор, толгой, шийр болон хагас боловсруулсан үхрийн махыг оруулахгүй. Хагас боловсруулсан үхрийн маханд жигнэсэн, лаазалсан, татсан махыг оруулна. 3 дугаар мөр. Адууны мах: Цул, ястай бүх төрлийн адууны махыг оруулна. Гэдэс, дотор, толгой, шийр болон хагас боловсруулсан адууны махыг оруулахгүй. Хагас боловсруулсан адууны маханд жигнэсэн, чанасан, лаазалсан, татсан махыг оруулна.

4 дүгээр мөр. Тэмээний мах: Цул, ястай бүх төрлийн махыг оруулна. Гэдэс, дотор, толгой, шийр, бөхний өөхийг оруулахгүй.

5 дугаар мөр. Ямааны мах: Цул, ястай бүх төрлийн махыг оруулна. Гэдэс, дотор, толгой, шийрийг оруулахгүй.

6 дугаар мөр. Гахайн мах: Утсан, чанасан, жигнэсэн бүх төрлийн гахайн махыг оруулна. Толгой, шийр, лаазалсан гахайн махыг оруулахгүй.

7 дугаар мөр. Хиам: Бүтэн утлагат болон хагас утлагат, чанамал, нарийн хиам болон зайдсыг оруулна.

8 дугаар мөр. Савласан сүү: Дотоодын үйлдвэрийн бүх төрлийн сүүг оруулна. Хэмжих нэгжийг заавал литрт шилжүүлэн биет хэмжээг гаргана.

9 дүгээр мөр. Тараг: Дотоодын үйлдвэрийн бүх төрлийн таргийг оруулна. Хэмжих нэгжийг заавал литрт шилжүүлэн биет хэмжээг гаргана.

10 дугаар мөр. Аарц: Боловсруулалт хийгдсэн, хийгдээгүй бүх төрлийн аарцыг оруулна. Боловсруулалт хийгдсэн аарцанд үйлдвэрийн аргаар боож, савласан аарцыг оруулна. Хэмжих нэгжийг заавал килограмд шилжүүлэн тооцно. 1000кг = 1т байна.

11-12 дугаар мөр. Өндөг: Том, жижиг хэмжээ, ангилал харгалзахгүй бүх төрлийн өндгийг оруулна.

13 дугаар мөр. Ургамлын тос: 1 литрийн хэмжээгээр савлагдсан бүх төрлийн ургамлын тосыг оруулна. Хэмжих нэгжийг заавал литрт шилжүүлэн биет хэмжээг гаргана.

14 дүгээр мөр. Гурил /дотоод/: Дотоодын үйлдвэрийн дээдийн дээд, ширхэгтэй дээд, дээд, 1 дүгээр, 2 дугаар зэргийн гурилыг оруулна.

15 дугаар мөр. Гурил /гадаад/: Импортын дээдийн дээд, ширхэгтэй дээд, дээд, 1 дүгээр, 2 дугаар зэргийн гурилыг оруулна.

16 дугаар мөр. Бүх төрлийн будаа: Бүх төрлийн цагаан будаа, шар будаа, гурвалжин будаа, хөц будааг оруулна.

17 дугаар мөр. Чихэр: Савласан, ууталсан мөн задгай килограммаар худалдаалагдаж буй бүх төрлийн чихрийг оруулна. Набор, шоколад, резинен зөөлөн чихэр, үзэмтэй үрлийг оруулахгүй.

18 дүгээр мөр. Элсэн чихэр: Бүх төрлийн элсэн чихрийг оруулна.

19 дугаар мөр. Төмс /дотоод/: Монголд ургасан бүх төрлийн төмсийг оруулна.

20 дугаар мөр. Төмс /гадаад/: Импортын бүх төрлийн төмсийг оруулна.

21-27 дугаар мөр. "Хүнсний ногоо" бүлэгт багтсан ногоонуудад дотоодын болон импортын ногоог хамтад нь оруулна.

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

УТАС: 261559

20... оны ...-р сарын ...-ны өдөр